ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/13 Сайншанд

Хөдөлмөрч Сэврэйчүүд дэд хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дах хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028" үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих "Хөдөлмөрч Сэврэйчүүд" дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилтийн явц үр дүнг жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013026

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/13 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

ХӨДӨЛМӨРЧ СЭВРЭЙЧҮҮД ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, шаардлага:

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.18. дахь заалт;

1.2. “Алсын хараа-2050” Монгол Улсыг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн “Бүс, орон нутгийн хөгжил” Зорилт 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно заалт;

1.3. Аймгийг 2024-2028 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл;

1.4. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн 2.3.2.6, 2.3.2.8, 2.3.2.9, дахь заалт;

1.5. Сэврэй сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ажлын байр нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар хүртээмжтэй эдийн засаг бий болгоно. Иргэдийн мэдлэг, өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчин бүрдүүлж, зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ улмаар дундаж давхаргыг тэлнэ. Сумын иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөрч Сэврэйчүүд” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ” заалтыг хэрэгжүүлэх.

Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Амьдралын баталгааг хангах, нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэх үндсэн зорилгоор Хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлалын зэрэг салбаруудыг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлж, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, технологи, инновацад суурилсан төслүүдийг бодлогоор дэмжиж, ажилгүйдэл, ядуурлын түвшин бууруулахыг зорин хөтөлбөрийг боловсруулаа.

Сумын хөдөлмөрийн насны нийт 1058 хүн ам байна. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй 37 хүн ам ажил хайгчаар бүртгэлтэй. Хөдөлмөрийн насны ижил хайгаагүй хүн амыг нарийвчлан үзвэл сургуульд сурдаг 46, тэтгэвэрт 290, малчин, хөдөлмөр эрхлэх чадваргүй 13, гэрээр ажилгүй хүүхдээ асарч байгаа 48 иргэн зэрэг судалгаа хөдөлмөрийн судалгааны үр дүнгээс харагдаж байна. Ажил эрхлэх боломжтой хөдөлмөрийн насны хүн амыг ажил хөдөлмөрт зуучлан байнгын ажилтай болгох, тогтмол цалинтай ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй зорилтот бүлгийн өрх иргэдийг хөтөлбөрөөр дамжуулан өрхийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг нэмэгдүүлж цаашлаад жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх нь өрх иргэдийг ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажил болно.

Иймд хөдөлмөр эрхлэх насны, боловсролын түвшин бага, өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, ахмад настныг асарч байгаа асран хамгаалагч, мөн ахмад настнуудын боломж нөхцөлд таарсан хөтөлбөр төсөл хэрэгжүүлж дэмжлэг үзүүлэх, залуучуудад гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан технологи, инновацад суурилсан төслүүдэд дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг бодлогоор нэмэгдүүлж, иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, холбон зуучлах үйл

ажиллагаагаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

Хөдөө аж ахуй, уул уурхай, аялал жуулчлал, аж үйлдвэрийн зэрэг стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлж, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өрхийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, технологи, инновацад суурилсан шинэ санаа шинэлэг санаачилгыг гаргасан төслүүдийг бодлогоор дэмжиж, ажилгүй иргэдийн тоог бууруулах.

Гурав : Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.1 . Өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх.

3.2. Уул уурхай, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбаруудын дэмжлэгтэйгээр ажлын байрыг нэмэгдүүлэх.

3.3. Зорилтот бүлгийн иргэдийн оролцоо, хөгжил, нийгмийн хамгааллыг бодлогоор дэмжих.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, уялдаа холбоо

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

4.1.1. Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх уялдаа

4.2.1. “Тогтвортой Хөгжсөн Сэврэй -2028 “ хөтөлбөр

4.2.2. Аймгийн “ Өсөлтийг өрх бүрд “ хөтөлбөр

4.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр

4.2.4. Хоршоо хөгжүүлэх сан

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн худалдаа арга хэмжээ зохион байгуулах.

5.2. Уул уурхай, аялал жуулчлалын бүс нутагт иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэхэд холбон зуучлах.

5.3. Өрхийн үйлдвэрлэгчдийн дунд “Шилдэг үйлдвэрлэгч өрх“ уралдаан зохион байгуулж, иргэдийн бүтээгдэхүүнийг сайжруулах тогтвортой тууштай ажиллахад урамшуулан олон нийтэд сурталчлан таниулах.

5.4. Өрх иргэдийн дунд төслийн уралдаан зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх.

5.5. Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй иргэдийг ажлын байранд зуучлах

5.6. Иргэдийг ажлын байрны болон төсөл хөтөлбөр боловсруулах сургалтад хамруулах, төрөл бүрийн зээл тусламжид зуучлах

5.7. Шинэ санаа санаачилга гарган үр дүнтэй ажиллаж байгаа иргэдийг урамшуулан чадавхжуулах, туршлага судлах арга хэмжээнд хамруулах.

5.8. Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх

Зургаа. Хөтөлбөрийн төсөв

6.1. Улсын болон орон нутгийн төсөв

6.2. Орон нутгийн хөгжлийн сан

6.3. Хоршоо хөгжүүлэх сан

6.4. Бусад

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ

7.1. Сумын Засаг даргын Тамгын газар, Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр халамжийн салбарын үйл ажиллагаатай уялдуулан байгууллагуудын хамтын оролцоотой хэрэгжүүлнэ.

7.2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас дэмжлэг үзүүлэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнг жил бүр сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

7.4. Хөтөлбөрийн явцын хяналт, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Найм. Хүрэх үр дүн

8.1. Өрх иргэн бүр ажилтай орлоготой болно .

8.2. Шинээр бий болсон ажлын байрны тоо нэмэгдсэн байна.

8.3. Байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэний тоо нэмэгдсэн байна.

8.4. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.

8.5. Иргэдийн өрхийн үйлдвэрлэл нэмэгдэж орлоготой болсон байна.

Ес. Хөтөлбөрийн үр дүн, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

9.1.Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин /оноор/			
			2024	2025	2026	2027	2028
1	Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх үзэсгэлэн худалдаа арга хэмжээ зохион байгуулах.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	4	4	4
2	Уул уурхай, аялал жуулчлалын бүс нутагт иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэхэд холбон зуучлах, ажлын байр бий болгох	Нийлүүлсэн бүтээгдэхүүний төрөл	1	2	2	3	4
3	Өрхийн үйлдвэрлэгчдийн дунд “Шилдэг үйлдвэрлэгч өрх“ уралдаан зохион байгуулж, иргэдийн бүтээгдэхүүнийг сайжруулах тогтвортой тууштай ажиллахад урамшуулан олон нийтэд сурталчлан таниулах.	Арга хэмжээний тоо	0	1	1	2	2
4	Өрх иргэдийн дунд төслийн уралдаан зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх. Сургалт арга хэмжээнд хамруулах	Шалгаруулсан төслийн тоо	4	2	3	4	4

-oOo-

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн
3/13 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт

ХӨДӨЛМӨРЧ СЭВРЭЙЧҮҮД ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч : Сумын Засаг даргын орлогч

Гишүүдэд: Засаг даргын Тамгын газрын дарга

Ц.Дашбат (ИТХ-ын төлөөлөгч, Эдийн засаг, төсөв санхүү, дэд бүтцийн хөгжлийн хорооны дарга)

Ахмадын хорооны дарга

Сумын залуучуудын холбооны дарга

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн холбооны тэргүүн

Засаг даргын Тамгын газрын Хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Нарийн бичиг: Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн

-oOo-